

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 05 сарын 26 өдөр

Дугаар A/22.

Арвайхээр сум

**Дархлаажуулалтын 10 хоногийг
зохион байгуулах тухай**

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах тухай” А/186 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Өнөөдрийн вакцин-Маргаашийн хамгаалалт” уриан дор 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн захирал, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан Дархлаажуулалтын 10 хоногийн мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дархлаажуулалтаас хоцорсон 15 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулах ажлыг эрчимжүүлж, дархлаажуулалтын ач холбогдол болон дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн талаар олон нийтэд зөв мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн захирал, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА  Н.ОЮУНТУЯА

622301071



Эрүүл мэндийн газрын даргын 2026
оны 05 дугаар сарын 26-ны өдрийн
4/22-дугаар тушаалын хавсралт

**“ӨНӨӨДРИЙН ВАКЦИН – МАРГААШИЙН ХАМГААЛАЛТ” УРИАН ДОР
ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН 10 ХОНОГИЙН МЭДЭЭЛЭЛ,
СУРТАЛЧИЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Үйл ажиллагаа	№	Хугацаа	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага
1. Эрүүл зан үйлийг хэвшүүлэх мэдлэг олгох, чадавхжуулах сургалтын чиглэлээр						
1.1	Эцэг эх, асран хамгаалагч нарт хүний папиллома вирусийн дархлаажуулалтын ач холбогдлыг сурталчлах сургалтыг үе шаттай зохион байгуулах	1.	2026.05.26- 2026.06.05	Зорилтот бүлгийн хэрэгцээг тодорхойлсон байна	Ерөнхий боловсролын сургууль, сум, өрхийн ЭМТ	ЭМГ, Боловсролын газар
		2.	2026.05.26- 2026.06.05	Анги бүлэг тус бүрээр зохион байгуулах сургалтын календарчилсан төлөвлөгөөг гаргасан байна	Ерөнхий боловсролын сургууль, сум, өрхийн ЭМТ	ЭМГ, Боловсролын газар
		3.	2026.05.26- 2026.06.05	Эцэг эх, асран хамгаалагчийн 90-с доошгүй хувийг хамруулах	Ерөнхий боловсролын сургууль, сум, өрхийн	ЭМГ, Боловсролын газар
1.2	10-14 настай хүүхдүүдэд хүний папиллома вирусийн халдвар, урьдчилан сэргийлэлт, вакцины ач холбогдлын талаар танхимын сургалт зохион байгуулах	5.	2026.05.26- 2026.06.05	Сургууль тус бүрт сургалтын календарчилсан төлөвлөгөөг гаргах	Ерөнхий боловсролын сургуулийн эмч нар	ЭМГ, сум, өрхийн ЭМТ
		6.	2026.05.26- 2026.06.05	Төлөвлөгөөний дагуу сурагчдын 95-с доошгүй хувийг хамруулсан байна	ЭМГ, сум, өрхийн ЭМТ	ЕБС-иуд
		7.	2026.05.26- 2026.06.05	Сургалтын өмнөх болон дараах үнэлгээг гаргах	Ерөнхий боловсролын сургууль, сум, өрхийн ЭМТ	ЭМГ, Боловсролын газар
1.3	Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж	8.	2026.05.26- 2026.06.05	Амбулаториор үйлчлүүлж буй иргэдийн 90-с доошгүй	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хөтөч	Сум, өрхийн эрүүл мэндийн төв

	буй иргэдийг хүний папиллома вирусийн халдвар, дархлаажуулалтын ач холбогдлын талаарх мэдээллээр тасралтгүй хангах			хувийг мэдээллээр хангасан байна.	сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан	Сум, өрхийн эрүүл мэндийн төв
		9.	2026.05.26-2026.06.05	Хэвтэн эмчлүүлж буй иргэдийг сургалтад бүрэн хамруулсан байна.	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч нар	Сум, өрхийн эрүүл мэндийн төв
		10.	2026.05.26-2026.06.05	Өдрийн эмчилгээнд хамрагдаж буй иргэдэд зөвлөгөө мэдээллийг бүрэн хүргэсэн байна	Өдрийн эмчилгээний эмч, сувилагч нар	Сум, өрхийн эрүүл мэндийн төв
		11.	2026.05.26-2026.06.05	Гэрийн эргэлт, тойролын хүн амын 90-с доошгүй хувьд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна	Гэрийн эргэлт тойролтоор яваа эмч, сувилагч нар	Сум, өрхийн эрүүл мэндийн төв
2. Урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр						
2.1	Дархлаажуулалтын ач холбогдол, товллын мэдээлэл бэлтгэж түгээх	12.	2026.05.26-2026.06.05	10 төрлийн зөвлөмж, 2 видео бичлэгийг бэлтгэн түгээх, Дархлаажуулалтын ач холбогдлын талаарх зөв ойлголттой иргэдийн эзлэх хувь (санал асуулгаар тогтооно).	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар
2.2	Улаанбурханы дэгдэлтийн үеийн дархлаажуулалтын талаар мэдээлэл бэлтгэн түгээх (Голомтын дархлаажуулалт, 6-8 сартай хүүхдийн улаанбурханы эсрэг дархлаажуулалт, 10-15 насны хүүхдийн улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалт, насанд хүрэгчдийн сайн дурын дархлаажуулалт)	13.	2026.05.26-2026.06.05	5 төрлийн зөвлөмж, 3 видео бичлэгийг бэлтгэн түгээж, нийт хүн амын 10-с доошгүй хувийг хамруулсан байна.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар

2.3	Улаанбурхан-гахай хавдар-улаануудын (УГУ) эсрэг вакцины ач холбогдлын талаар мэдээлэл бэлтгэн түгээх	14.	2026.05.26- 2026.06.05	Зорилтот бүлгийн иргэдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага дээшилснээр вакцины товлолт болон нэмэлт тунгийн хамралт 95 хувьд хүрсэн	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар
2.4	Хүний папиллома вирусийн (ХПВ) вакцины ач холбогдлын талаар мэдээлэл түгээх, сайн дурын дархлаажуулалтын талаар мэдээлэл бэлтгэн түгээх	15.	2026.05.26- 2026.06.05	Зорилтот бүлгийн иргэдийн 90-ээс дээш хувь нь ХПВ вакцины ач холбогдлын талаар үнэн зөв мэдээлэлтэй болж, 11 настай охид, хөвгүүдийн товлолт дархлаажуулалтын хамралт нэмэгдсэн байна	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар
2.5	Гепатит В вирусийн эсрэг вакцины ач холбогдол, сайн дурын дархлаажуулалтын талаар мэдээлэл бэлтгэн түгээх	16.	2026.05.26- 2026.06.05	Нийт хүн амын 10-с доошгүй хувийг мэдээллээр хангасан байна.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар
2.6	Сүрьеэгийн эсрэг (БЦЖ), В вируст гепатитын вакцины талаар мэдээлэл бэлтгэн түгээх	17.	2026.05.26- 2026.06.05	Төрөх, төрсний дараах иргэдийн 98-аас дээш хувьд эмнэлгээс гарахаас өмнө БЦЖ болон ВВГ вакцины ач холбогдлыг сурталчилан таниулсан байна	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар
2.7	Сахуу, татран, хөхүүл ханиадын вакцины талаар мэдээлэл бэлтгэн түгээх	18.	2026.05.26- 2026.06.05	Товлолт насанд хүрсэн хүүхдүүдийн 90 хүртэлх хувьд 'Тавт' болон 'Сахуу-Татран'-гийн вакцины талаар үнэн зөв мэдээллийг хүргэсэн байна	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар
2.8	Халдварт саагийн эсрэг вакцин, цочмог сул саажилтын талаар мэдээлэл бэлтгэн түгээх	19.	2026.05.26- 2026.06.05	Зорилтот бүлгийн иргэдийн 95-аас дээш хувь нь халдварт саагийн вакцины ач холбогдлыг ойлгосон байна	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар

2.9	Хемофилюс инфлюэнза В халдварын эсрэг вакцины талаар мэдээлэл бэлтгэн түгээх	20.	2026.05.26- 2026.06.05	Зорилтот бүлгийн эцэг эхчүүдийн 95-аас дээш хувь нь "Тавт вакцин"-д багтсан Hib бүрэлдэхүүний ач холбогдлыг мэддэг болж, хүүхдүүд товлолын дагуу 2, 3, 4 сартайдаа дархлаажуулалтад бүрэн хамрагдсан байна	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар
2.10	Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн талаар мэдээлэл бэлтгэн түгээх	21.	2026.05.26- 2026.06.05	Дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн 95-аас дээш хувь нь вакцины дараа илрэх ердийн урвал ба хүндрэлийг ялгаж таньдаг болж, тусламж шаардлагатай үед эрүүл мэндийн байгууллагад хандах мэдлэгтэй болсон байна.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар
2.11	Дархлаажуулалтын хамрагдахлыг нэмэгдүүлэх уриалга, сануулга түгээх	22.	2026.05.26- 2026.06.05	Харьяа төрийн болон төрийн бус байгууллагуудын 90-с доошгүй хувийг уриалгад оролцуулах	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн газар

--oOo--